

**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ**

2000 оны 04 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Контракт байгуулж иргэнийг авч ажиллуулж болох ажил (мэргэжил), албан тушаалын жагсаалтыг хавсралтыг ёсоор баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, мониторингийн газар (П.Алтанхуяг)-т даалгасугай.

САЙД

С.СОНИН

Эрүүл мэнд, нийгмийн
хамгааллын сайдын 2000
оны 93 тоот тушаалын
хавсралт

**КОНТРАКТ БАЙГУУЛЖ ИРГЭНИЙГ АВЧ
АЖИЛЛУУЛЖ БОЛОХ АЖИЛ (МЭРГЭЖИЛ),
АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ**

А.Ажил (мэргэжил):

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын <<Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт батлах тухай>> 1998 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/315 тоот тушаалаар баталсан <<Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт>>-д дурдсан ажил (мэргэжил)

Б.Албан тушаал:

1.Төрийн (контрактын гэрээгээр ажиллахыг хууль тогтоомжоор хориглосноос бусад) ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, албан хаагч

2.Аж ахуйн нэгж, байгууллагын захирал, гүйцэтгэх захирал, ерөнхий менежер, алба, хэлтэс, тасгийн менежер, аж ахуйн нэгж байгууллагын доторх нэгж, хэсгийн удирдах албан тушаал.

*Тайлбар: Ажил олгогч нь иргэний гоц буюу ховор авьяас,өндөр ур чадварыг нь нотлох үнэмлэх (сертификат), түүний туршлага болон бүтээлийг нь үндэслэн өөрийн сонголт шийдвэрээр гэрээ байгуулна.